Ярилцлага өгөгчийн нэр	Дамчаа	Дугаар	L363
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Мандалговь хот, Сайнцагаан сум
Төрсөн газар	Мандалговь хот, Сайнцагаан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зүүн ганжуурын хийд	Сүм хийдийн дугаар	ДУГУ 083
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Жужа

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Зүүн ганжуурын хийд

Жужа: Тэгэхээр хэдэн онд байгуулагдсан бэ?

Дамчаа: Хэдэн онд гэдгийг нь нарийн сайн мэдэхгүй. Шавилж сууж байгаагүй. Зүү гаруй ламтай байсан байх. Таавар шүү. Баруун ганжуур бол дунд гол гэдэг газар байсан юм. Харин Зүүн ганжуур нь Баяндаргуа гэдэг газар байсан . Мөн зүү орчим ламтай байсан байх.

Жужа: Баруун ганжуур хэдэн дугантай байсан бэ?

Дамчаа: 2-3 сүмтэй байсан байх.

Жужа: Суварга байсан уу?

Дамчаа: Ганц нэг суварга байсан байх.

Жужа: Дуганууд юугаар хийгдсэн байсан бэ?

Дамчаа: Модон дуганууд байсан байх. Сайн мэдэхгүй шүү.

Жужа: Гадуураа хэрмэн хашаатай байсан уу?

Дамчаа: Үгүй ээ, задгай байсан.

Жужа: Тахидаг овоо байсан уу?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь эвхэн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Дамчаа: Мэдэхгүй ээ, сайн мэдэхгүй юм. Харин Зүүн ганжуурыг арай илүү мэднэ. Зүүн ганжуур Баяндаргуа гэдэг газар байсан, их бага хоёр дугантай, ганжуурын дуган, ламиран дуган гэж хоёр дугантай. Тэнд хурал номоо хурдаг. 100 гаруй ламтай, хоёр суваргатай, ганжуур нь зүүн талдаа , ламиран дуган нь баруун талдаа. Нэг суварга нь өмнөө, нөгөөх нь хойноо байдаг.

Жужа:Хийдийн хамба лам хэн гэдэг хүн байсан бэ?

Дамчаа: Зүүн Ганжуурыг нь би хэлье. Барууныг бол мэдэхгүй. Зүүн Ганжуурын их ламыг Донддов гэж хүн байсан болов уу гэж тааварлаж байна.

Жужа: Цам, майдар гардаг байсан уу?

Дамчаа: Майдар лав эргэдэг байсан, цам бүжиг гарч байгаагүй. Цам гардаггүй байсан. баруун ганжуурт бол майдар эргэдэг л байсан байх. Би нарийн мэдэхгүй байна. Зүүнийг нь арай илүү мэдэж байна. Зүүн Ганжуур хойноо нэг Цагаан овоотой, зүүн хойноо бас нэг Цагаан овоотой. Эднийг тахиж, бэсрэг наадам хийдэг байсан. одоо ч түүрь энэ тэр нь бий.

Жужа: Хятадууд байсан уу, тэнд?

Дамчаа: Үгүй ээ, байгаагүй байх. Тэгж санаж байна.

Жужа: Зоч лам , лүйжинч нар байсан уу?

Дамчаа: Үгүй одоо байсан л байх. Сайн санахгүй байна. Баруун Ганжуурт ч бас лүйжинч лам нар байсан юм гэнэ лээ.

Жужа: Борчүүд харчууд байсан уу?

Дамчаа: Лам нар нь борчүүд нь нийлээд Зүүн, баруун хүрээ гэж хоёр хэсэг, хоёр бөөнөөрөө байдаг байсан. Одоогоор бол лагерийн айлууд юм даа.

Жужа: Энэ хоёр хийдээс өөр хийд байсан уу?

Дамчаа: Онцын юм байгаагүй. Говь-Угтаал сумын төвийн хойно нэг огтор жас байсан юм. Сонссоноос цаашгүй сайн мэдэхгүй байна.

Жужа: За баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь эвхэн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон